



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.16

No

01/26 ДУА-2017/115/ОА-ТЦ/С

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА С.САЙНБАЯР ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад 745,000.00 /долоон зуун дөчин таван мянга/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баярын үйл ажиллагааг санхүүжүүлж, 245,000.00 /хоёр зуун дөчин таван мянга/ төгрөгийг тэмцээн уралдааны зардалд зарцуулсан Энэ нь Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 47-р тогтоолын 2.5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, Төсвийн тухай хуулийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлтийг байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг,
2. Засаг даргын нөөцөөс Засаг даргын захирамж шийдвэр, гэрээ дүгнэсэн баримтгүйгээр АШУҮИС-ийн оюутны төлбөр 500,000.00 /таван зуун мянга/ төгрөг төлсөн.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1 /анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно/, 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дурмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зорчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулат бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсон/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах;
2. Хүчин төгөлдөр бус, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Сайнбаяр, нягтлан бодогч Т.Хүдэрчулуун нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

**ӨГСӨН<sup>1</sup>:**

АХЛАХ АУДИТОР  Б.ГАНТУЯА

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ

**ЗӨВШӨӨФСӨН:**

С.САЙНБАЯР

Т.ХҮДЭРЧУЛУУН

  
ЗНЧ 0001

---

<sup>1</sup> Албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/